

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/16/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10-11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11-12
3.5 Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл.....	12-15
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18-19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТТЗ	Төсвийн Төвлөрүүлэн Захирагч



ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.БЯМБАСҮРЭН ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.22 № 01/276
танай _____ -ны № _____ -т

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй зүйл илэрлээ. **Үүнд:**

- Төмөрбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь сумын орон нутгийн орлогыг 48.5 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 1.7 сая төгрөгөөр нийт 50.2 сая төгрөгөөр тасалсан байна. Уг зөрчлийг материаллаг зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон материаллаг түвшнээс 31.5 сая төгрөгөөр давсан.
- Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Үйл ажиллагааны орлогыг 0.6 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 2.0 сая төгрөгөөр, бууны албан татварын орлогыг 1.3 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 0.9 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 0.4 сая төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 0.4 сая төгрөгөөр, Газрын төлбөрийн орлогыг 1.0 сая төгрөгөөр, торгуулийн орлогыг 8.3 сая төгрөгөөр нийт 98.9 сая төгрөгөөр тасалсан байна.
- Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 0.3 сая төгрөгөөр, дотоодын бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 1.4 сая төгрөгөөр нийт 1.7 сая төгрөгөөр тасалсан байна.
- Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь нийт 100.6 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэн байна.

Аудитын гол асуудал

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 9 иргэнтэй холбоотой 28.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Төмөрбулаг сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 96.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/Мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,052,263.6	542,976.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	254,635.2	295,867.0
33	АВЛАГА	225,384.7	96,184.3
35	БАРАА МАТЕРИАЛ	572,243.7	150,924.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,574,034.4	998,375.8
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	19,000.0	16,000.0
37300	Урт хугацаат зээл	19,000.0	16,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,555,034.4	982,375.8
39200	Биет хөрөнгө	7,357,919.0	953,039.6
39300	Биет бус хөрөнгө	197,115.3	29,336.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,626,298.0	1,541,351.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	47,365.1	3,642.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	47,365.1	3,642.2
41300	Өглөг	47,365.1	3,642.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,578,932.9	1,537,709.7
51	Засгийн газрын хувь оролцоо	8,578,932.9	1,537,709.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,849,758.8	416,511.2
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,849,758.8	416,511.2
51200	Хуримтлагдсан үр дүн	4,942,874.8	1,001,844.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,786,299.2	119,353.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,626,298.0	1,541,351.9

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/Мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,901,207.1	1,275,894.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	152,834.0	285,849.5
110	Орлогын албан татвар	41,408.8	182,921.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	41,408.8	193,366.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-10,444.9
113	Хөрөнгийн албан татвар	39,804.6	41,514.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	71,620.6	61,413.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	860,499.9	53,865.2
120	Нийтлэг татварын бус орлого	850,464.5	53,865.2
121	Хөрөнгийн орлого	10,035.4	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,887,873.2	936,179.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,367,570.3	1,169,080.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,367,570.3	1,169,080.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,277,707.9	1,112,268.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,753,343.7	380,565.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	235,801.5	48,590.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	448,549.3	464,880.0
2104	Хангамж, бараа материалын зардал	97,401.1	45,416.5
2105	Нормативт зардал	332,822.3	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,051.7	12,883.6
2107	Томиллолт, зочны зардал	2,467.2	1,560.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,143.1	44,159.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	373,128.1	114,212.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,862.4	56,811.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	533,636.8	106,813.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,250.0	7,115,528.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	515,386.8	-7,008,714.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,097,112.8	1,292,780.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	152,834.0	285,849.5
110	Орлогын албан татвар	41,408.8	182,921.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	41,408.8	193,366.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-10,444.9
113	Хөрөнгийн албан татвар	39,804.6	41,514.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	71,620.6	61,413.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,607.7	6,265.6
1181	Газрын төлбөр	2,772.0	1,154.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	60,240.9	53,993.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,475.5	68,875.0
120	Нийтлэг татварын бус орлого	102,440.1	68,875.0
121	Хөрөнгийн орлого	10,035.4	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,831,803.2	938,055.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,833,317.2	1,243,478.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,833,317.2	1,243,478.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,742,305.4	999,329.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,752,468.4	380,565.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	236,098.1	48,755.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	421,343.9	464,757.3
2104	Хангамж, бараа материалын зардал	70,189.4	30,872.7
2105	Нормативт зардал	168,041.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,268.2	14,872.2
2107	Томилголт, зочны зардал	2,467.2	1,560.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,479.4	23,979.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,949.8	33,967.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,091,011.8	244,148.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	263,795.6	49,301.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	66,780.0	8,070.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,780.0	8,070.0
2200	Дотоод эх үүсвэрээр	66,780.0	8,070.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-66,780.0	-8,070.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-60,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	60,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	137,015.6	41,231.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	117,619.7	254,635.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	254,635.2	295,867.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,987,782.1	0.0	7,987,782.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	78,853.1	0.0	78,853.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,066,635.2	0.0	8,066,635.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-3,089.1	0.0	-3,089.1
9	Тайлант үеийн үр дүн	515,386.8	0.0	515,386.8
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,578,932.9	0.0	8,578,932.9
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,578,932.9	0.0	8,578,932.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-32,491.5	0.0	-32,491.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,546,441.4	0.0	8,546,441.4
19	Тайлант үеийн үр дүн	-7,008,714.9	0.0	-7,008,714.9
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,537,709.7	0.0	1,537,709.7

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,568,028.5	1,222,742.5	345,286.0	78.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,413,859.0	1,222,742.5	191,116.5	86.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,031,048.0	981,431.1	49,616.9	95.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	390,996.4	380,565.8	10,430.6	97.3
210101	Үндсэн цалин	324,606.3	313,052.5	11,553.8	96.4
210102	Нэмэгдэл	62,867.9	48,508.9	14,359.0	77.2
210104	Урамшуулал	3,522.2	19,004.4	(15,482.2)	539.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,490.0	48,755.6	2,734.4	94.7
210201	Тэтгэврийн даатгал	35,646.4	33,404.2	2,242.2	93.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,193.1	4,061.6	131.5	96.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,110.2	3,020.4	89.8	97.1
210204	Ажилгүйдлийн даатгал	777.8	752.7	25.1	96.8
210205	Эрүүл мэндийн даатгал	7,762.5	7,516.7	245.8	96.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	485,555.6	464,695.1	20,860.5	95.7
210301	Гэрэл, цахилгаан	20,000.0	15,209.9	4,790.1	76.0
210302	Түлш, халаалт	459,605.6	446,673.7	12,931.9	97.2
210303	Цэвэр, бохир ус	5,950.0	2,811.5	3,138.5	47.3
2104	Хангамж, бараа материалын зардал	30,127.0	28,545.3	1,581.7	94.7
210401	Бичиг хэрэг	3,027.0	3,007.0	20.0	99.3
210402	Тээвэр, шатахуун	18,900.0	18,005.2	894.8	95.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,400.0	4,545.6	(145.6)	103.3
210404	Ном, хэвлэл	300.0	275.0	25.0	91.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500.0	712.5	787.5	47.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000.0	2,000.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,746.2	13,746.2	-	100.0
210604	Урсгал засвар	13,746.2	13,746.2	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,710.0	1,560.0	150.0	91.2
210702	Дотоод албан томилолт	1,710.0	1,560.0	150.0	91.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,745.4	28,087.6	7,657.8	78.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,063.4	26,843.8	7,219.7	78.8
210803	Даатгалын үйлчилгээ	250.0	66.0	184.0	26.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250.0	247.5	2.5	99.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132.0	22.8	109.2	17.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	900.0	767.5	132.5	85.3
210807	Газрын төлбөр	150.0	140.0	10.0	93.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,677.4	15,475.6	6,201.8	71.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,000.0	11,798.2	6,201.8	65.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,677.4	3,677.4	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	382,811.0	241,311.3	141,499.7	63.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	366,578.2	225,078.5	141,499.7	61.4
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	366,578.2	225,078.5	141,499.7	61.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,232.8	16,232.8	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,432.8	15,432.8	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800.0	800.0	-	100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	154,169.5	-	154,169.5	-
230001	Эргэж төлөгдөх зээл	154,169.5	-	154,169.5	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,568,028.5	1,226,070.9	341,957.6	78.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	131,915.5	131,915.4	0.1	100.0

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	131,915.5	131,915.4	0.1	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,114,063.4	1,029,154.6	84,908.8	92.4
320001	Орон нутгийн төсвөөс	1,114,063.4	1,029,154.6	84,908.8	92.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	322,049.6	65,000.9	257,048.7	20.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	61,000.0	58,983.0	2,017.0	96.7
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,800.0	6,017.9	782.1	88.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	254,249.6	-	254,249.6	-
4	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	205,566.4	-205,566.4	-
5	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	208,894.9	-208,894.9	-

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,430.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,430.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,968.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62.2
210301	Гэрэл, цахилгаан	62.2
2104	Хангамж, бараа материалын зардал	2,327.4
210401	Бичиг хэрэг	35.0
210402	Тээвэр, шатахуун	1,928.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	334.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,126.0
210604	Урсгал засвар	1,126.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,961.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,961.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,491.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,491.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,462.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10.5
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	10.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	575.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	575.5
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,876.1
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,876.1
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,420.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,420.2
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	620.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,340.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,459.4
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-10.5
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Төмөрбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Төмөрбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Олон нийтийн оролцоонд тулгуурласан, ил тод хариуцлагатай засаглалтай иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээг эрхэмлэн, сумын хөгжил дэвшлийг оновчтой бодлогоор хангана” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна

Төмөрбулаг сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 96.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагуудын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль улсын төсөвт, Соёлын төв болон Эрүүл мэндийн төв нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу тус тус улсын төсөвт шилжсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Засаг даргын 2022 оны 04 сарын 06 өдрийн А/58 тоот захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, цаг ашиглалт, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулал, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, орон нутгийн орлогын гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа, шилэн дансны мэдээлэл, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын

дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,084.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	254.6	295.9	41.3
Авлага	225.4	96.2	-129.2
Бараа материал	572.2	150.9	-421.3
Үндсэн хөрөнгө	7,555.0	982.4	-6,572.6
Нийт хөрөнгө	8,626.3	1,541.4	-7,084.9
Өр төлбөр	47.4	3.6	-43.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,578.9	1,537.7	-7,041.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,626.3	1,541.4	-7,084.9

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэж бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн дансны үлдэгдлүүд буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 41.3 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 8.9 сая төгрөг, ОНХС-ийн дансанд 57.4 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэлд 151.5 сая төгрөг нийт 295.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
2. Авлагын үлдэгдэлд ОНХС-ийн дансанд бүртгэлтэй Шидэт гал ХХК-аас авах 10.0 сая төгрөгийн зураг төсвийн үнийн авлага, ЗДТГ-ын НДШ-ийн 0.2 сая төгрөгийн авлага, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн 86.0 сая төгрөгийн авлага нийт 96.2 сая төгрөгийн авлагатай байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн өмнөх оны үлдэгдлээс 64.0 сая төгрөгийн авлагыг барагдуулсан бөгөөд Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 9 иргэнтэй холбоотой 28.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3. Бараа материалын дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэнээр нийт 452.7 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн нь нөлөөлсөн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль 223.6 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 51.9 сая төгрөг, Соёлын төв 47.4 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 130.0 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлсэн байна.
4. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургуулийн 4,137.2.6 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 178.9 сая төгрөг, Соёлын төв 1,631.5 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 712.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт тус тус шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

5. Өр төлбөрийн дансны үлдэгдэл буурсан нь Соёлын төвийн 29.7 сая төгрөгийн өглөг, эрүүл мэндийн төвийн 10.0 сая төгрөгийн өглөг өглөгийн данснаас хасаж тайлагнасан болон ЗДТГ-ын 6.5 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөгийг барагдуулсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,275.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 2,325.3 сая төгрөгөөр буюу 32.7 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөгөөр/	
			зөрүү	Хувь
Татварын орлого	152.8	285.8	133.0	187.0
Татварын бус орлого	860.5	53.9	-806.6	6.3
Тусламж санхүүжилтийн орлого	2,887.9	936.2	-1,951.7	32.4
Нийт дүн	3,901.2	1,275.9	-2,625.3	32.7

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсөвт шилжиж улсын төсвөөс авах санхүүжилт хасагдсанаас шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,306.5 сая төгрөгийн орлогын давхардсан 14 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,128.2 сая төгрөгийн орлогын давхардсан 12 гүйлгээ устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд 1,169.1 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Өмнөх онтой харьцуулахад 2,198.5 сая төгрөгөөр буюу 34.7 хувиар буурсан байна.

Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөгөөр/	
			зөрүү	Хувь
Бараа ажил үйлчилгээний зардал	3,277.7	1,112.3	-2,165.4	33.9
Урсгал шилжүүлэг	89.9	56.8	-33.1	63.2
Үйл ажиллагааны зардлын дүн	3,367.6	1,169.1	-2,198.5	34.7

Эх сурвалж: Төмөрбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Нийт зардлын дүн буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжиж орон нутгаас байр ашиглалтын зардлыг санхүүжүүлэх болсноор төсвийн зардал 34.7 хувиар буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,306.5 сая төгрөгийн зарлагын давхардсан 14 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,128.2 сая төгрөгийн зарлагын давхардсан 12 гүйлгээ устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж орон нутгаас санхүүжүүлэх Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардлыг тусгаж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төмөрбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 1,542.2 сая төгрөгийн төсөв баталснаас 1,128.6 сая төгрөгийг урсгал зардалд, 346.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, Эргэж төлөгдөх зээлийн зардалд 66.8 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 139.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, санхүүгийн дэмжлэгээс 874.3 сая төгрөгийг, сумын орон нутгийн орлогоос 340.8 сая төгрөгийг, үндсэн болон туслах үйл

ажиллагааны орлогоос 67.8 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 119.3 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Төмөрбулаг сумын ИТХ-ын 2027 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор төсөвт 25.8 сая төгрөгийн нэмэх тодотгол хийж төсвийг 1,568.0 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн орлогын гүйцэтгэл

Гүйцэтгэлээр Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 65.0 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 253.4 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас 131.9 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 119.3 сая төгрөгийг, санхүүгийн дэмжлэгээс 656.5 сая төгрөгийг нийт 1,226.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Төмөрбулаг сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолд зааснаар Төмөрбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 338.2 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 289.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 85.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	3.0	2.4	-0.6	80.0
Хөрөнгийн орлого	23.0	21.0	-2.0	91.3
Хөрөнгө борлуулсны орлого	4.3	6.1	1.9	143.8
Шууд бус орлого	0.1	0.0	0.0	78.6
Цалин хөлс шагнал урамшуулал	141.9	163.8	22.0	115.5
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-27.8	-10.4	17.4	37.6
Бууны албан татвар	2.7	1.4	-1.3	52.6
Малд ногдуулах албан татвар	119.4	35.3	-84.1	29.6
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	4.0	4.8	0.8	120.0
Улсын тэмдэгтийн хураамж	4.3	3.4	-0.9	79.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.4	0.0	-0.4	7.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3.2	2.8	-0.4	88.4
Газрын төлбөр	2.2	1.2	-1.0	52.5
Ойн нөөц ашигласны төлбөр	45.4	52.7	7.3	116.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.1	0.1	0.0	100.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.0	1.0	0.0	100.0
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.2	0.2	0.0	100.0
Торгуулийн орлого	11.0	2.7	-8.3	24.5
Бусад орлого		1.2	1.2	
ТӨСВИЙН ОРЛОГО	338.2	289.7	-48.5	85.7

Эх сурвалж: Төмөрбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Төмөрбулаг сумын орон нутгийн орлого 48.5 сая төгрөгөөр тасрахад малд ногдуулах албан татварын орлого 84.1 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 8.3 сая төгрөгөөр тасарсан нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Үйл ажиллагааны орлого 0.6 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 2.0 сая төгрөгөөр, бууны албан татварын орлого 1.3 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 0.9 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 0.4 сая төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 0.4 сая төгрөгөөр, Газрын төлбөрийн орлого 1.0 сая төгрөгөөр, торгуулийн орлого 8.3 сая төгрөгөөр нийт 98.9 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 17.3 сая төгрөгөөр төлөвлөж 23.0 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 5.7 сая төгрөг буюу 32.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №5: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/сая төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	0.5	0.2	-0.3
2	Газрын үл хөдлөх хөрөнгийн татвар		0.02	0.02
3	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	13.5	17.4	3.9
4	Зам ашигласны төлбөр	3.4	5.4	2.0
	Нийт дүн	17.3	23.0	5.7

Эх сурвалж: Төмөрбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 5.2 сая төгрөгөөр төлөвлөж 4.1 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 1.1 сая төгрөгөөр тасалсан байна.

Хүснэгт №6: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/сая төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	0.7	0.4	-0.3
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	3.0	1.6	-1.4
3	Агаарын бохирдлын төлбөр	1.5	2.0	0.5
	Нийт дүн	5.2	4.1	1.1

Эх сурвалж: Төмөрбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 0.3 сая төгрөгөөр, дотоодын бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 1.4 сая төгрөгөөр нийт 1.7 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Үйл ажиллагааны мөнгөн орлогын талаар

Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 1,568.0 сая төгрөгөөр төлөвлөж, 1,292.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 82.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 66.8 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 64.0 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 1,568.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,052.3 сая төгрөгийг урсгал зардалд, 361.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 154.2 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 997.6 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 225.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,222.7 сая төгрөг буюу 77.8 хувьтай байгаа нь Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүйтэй холбоотой байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 10.4 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.7 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 20.9 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 1.6 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 7.6 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 6.2 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 141.5 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 17 төсөл арга хэмжээнд 366.6 сая төгрөг батлагдсанаас 14 төсөл арга хэмжээнд 225.1 сая төгрөгийг зарцуулж 117.6 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Энэ нь Малын тоо толгойн албан татварын орлого тасарснаас шалтгаалан 1 арга хэмжээ, материалын үнэ нэмэгдсэнээс шалтгаалан гүүр барих болон зам даваа засах 2 арга хэмжээ тус тус хэрэгжээгүй байна.

Сумын Засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилт 1,222.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 77.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь хандив тусламжаар 0.6 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 4.3 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд худгийн орлого 5.0 сая төгрөг, тэжээлийн үнэ 18.5 сая төгрөг нийт 28.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 26.0 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 2.4 сая төгрөгийг нийт 28.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 1/06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 67.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 54.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,169.1 сая төгрөгийг сонгож 18.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор харьяа байгууллагуудын төсөвт нийт 345.3 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэх явцад зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 41.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт №7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	41.0	3	41.0	100
Нийт дүн	3	41.0	3	41.0	100

/сая төгрөгөөр/

Өмнөх оны 41.0 сая төгрөгийн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Тайлант онд боловсролын, соёл, эрүүл мэндийн салбарын 4 байгууллага улсын төсөвт шилжсэн тул хаалтын тайлан гаргаж нэгтгэсэн байна.

Аудитаар нийт 128.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 100.6 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч 28.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 46.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Аудитын явцад 46.7 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Төмөрбулаг сумын ТТЗ нь сумын орон нутгийн орлогыг 48.5 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 1.7 сая төгрөгөөр нийт 50.2 сая төгрөгөөр тасалсан байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Үйл ажиллагааны орлого 0.6 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 2.0 сая төгрөгөөр, бууны албан татварын орлого 1.3 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 0.9 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 0.4 сая төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 0.4 сая төгрөгөөр, Газрын төлбөрийн орлого 1.0 сая төгрөгөөр, торгуулийн орлого 8.3 сая төгрөгөөр нийт 98.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 0.3 сая төгрөгөөр, дотоодын бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 1.4 сая төгрөгөөр нийт 1.7 сая төгрөгөөр тасалсан байна.

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь нийт 100.6 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

1.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 9 иргэнтэй холбоотой 28.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Харьяа байгууллагуудын алдаа												
Төмөрбулаг сумын ЗДТГ	5	46.7			5	46.7	5	46.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	100.6			1	100.6						
Хугацаа хэтэрсэн зээлийн авлага	1	28.0					1	28.0				
Дүн	2	128.6			1	100.6	1	28.0				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Төмөрбулаг сумын ЗДТГ	1											

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

А.ЭРДӨНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО: